



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/55

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Есөнзүйл сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах” гэрээний нийт үнийн дүн 45,000,000 (дөчин таван сая) төгрөгөөс үлдэгдэл 10,000,000 (арван сая) төгрөгийг олгосугай.

2. Дээрх 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн үндсэн чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100130